



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/001/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:  
[www.Umnugovi@audit.mn](mailto:www.Umnugovi@audit.mn)  
Өмнөговь аймаг  
Даланзадгад хот  
2026 он

Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор:  
Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn  
Ахлах аудитор: Г.Шижирболд  
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
3. Аудитын илрүүлэлт .....	10
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	14

### **Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНТХ	Орон нутгийн төсвийн хөрөнгө

---



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.13 № 276  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

"ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААНЫ  
ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨХК-НЫ  
ЗАХИРАЛ Д.ЭРДЭНЭТӨГС ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Даланзадгадын дулааны цахилгаан станц" ТӨХК-ны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар өглөг, авлага өмнөх оноос өссөн, спортын тэмцээн уралдаанд хөрөнгө зарцуулсан, ажилтнуудын цалингаас хуульд заагаагүй суутгал хийсэн зэрэг нийт 2,290.1 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8, Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд 4,002.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 3,134.6 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд, 867.9 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийг бараа материалд бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний дүн үзсэн асуудал

байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант оны зорилтод түвшинд орлогыг 13,070.4 сая, зарлагыг 16,050.4 сая, алдагдлыг 2,980.0 сая төгрөг байхаар баталж, гүйцэтгэлээр 13,719.1 сая төгрөгөөр орлого бүрдүүлэн 13,829.2 сая төгрөг зарцуулж, 110.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус компани нь Төрийн өмчит хаалттай хувьцаат компани бөгөөд нийт хувьцааны 66 хувийн төлөөллийг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 34 хувийг "Эрчист Монгол" ХХК хэрэгжүүлж байна.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБЯЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	55,261,278.60	61,052,259.32
1.1.02	Дансны авлага	260,723,801.33	417,069,762.93
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	4,249,119.19	4,249,119.19
1.1.06	Бараа материал	1,564,069,957.28	2,842,569,774.64
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	820,927,390.26	485,561,548.15
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,705,231,546.66	3,810,502,464.23
1.2.01	Үндсэн хөрөнгө	10,047,683,967.17	13,131,182,990.34
1.2.02	Биет бус хөрөнгө	1,695,538,865.45	1,693,273,612.64
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,743,222,832.62	14,824,456,602.98
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,448,454,379.28</b>	<b>18,634,959,067.21</b>
2.1.1.01	Дансны өглөг	1,808,039,528.04	1,844,016,067.52
2.1.1.02	Цалингийн өглөг	6,267,068.87	7,686,062.93
2.1.1.03	Татварын өр	3,509,181,701.11	4,471,081,980.64
2.1.1.04	НДШ - ийн өглөг	1,367,679,813.42	476,301,266.50
2.1.1.05	Богино хугацаат зээл	5,144,787,369.00	5,549,787,369.00
2.1.1.06	Хүүний өглөг	1,175,935,037.47	1,178,103,812.47
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	1,303,463,657.38	926,396,948.22
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	358,912,430.90	495,141,412.48
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	14,674,266,606.19	14,948,514,919.76
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр /ОНХОруулалт/	4,071,994,122.10	8,074,488,683.37
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	356,654,135.00	356,654,135.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,428,648,257.10	8,431,142,818.37
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>19,102,914,863.29</b>	<b>23,379,657,738.13</b>
2.3.01	Өмч: - төрийн	8,337,595,020.45	8,337,595,020.45
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,808,076,252.49	4,808,076,252.49
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	1,655,056,500.00	1,655,056,500.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-19,455,188,256.95	-19,545,426,443.86
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-110,162,423.71
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-19,455,188,256.95	-19,435,264,020.15
2.3.11	Эздийн өмчийн дүн	-4,654,460,484.01	-4,744,698,670.92
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>14,448,454,379.28</b>	<b>18,634,959,067.21</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	6,770,124,673.62	7,536,267,344.26
02	Борлуулалтын өртөг	12,925,971,504.92	11,136,348,806.31
03	Нийт ашиг( алдагдал)	-6,155,846,831.30	-3,600,081,462.05
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	2,973,914.85	66,918,060.33
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Хандивын орлого	3,193,804,330.88	489,981,800.00
08	Бусад орлого	4,950,533,333.58	5,625,527,516.43
08.1	Орлогын дүн	8,147,311,579.31	6,182,427,376.76
09	Борлуулалт, маркетингийн зардал	5,251,982.70	10,864,023.28
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,551,787,588.42	2,090,241,065.12
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	713,872,280.16	591,744,914.82
12.1	Зардлын дүн	2,270,911,851.28	2,692,850,003.22
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-56,893.91	341,664.80
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	72,540,545.46	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг ( алдагдал)	0.00	0.00
17.1	Олз, гарзын дүн	72,483,651.55	341,664.80
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	-206,963,451.72	-110,162,423.71
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
19.1	Хойшлогдсон татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-206,963,451.72	-110,162,423.71
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-206,963,451.72	-110,162,423.71

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	8,337,595,020.45	4,808,076,252.49	1,655,056,500.00	-19,455,188,256.95	-4,654,460,484.01
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	19,924,236.80	19,924,236.80
3	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-110,162,423.71	-110,162,423.71
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	8,337,595,020.45	4,808,076,252.49	1,655,056,500.00	-19,545,426,443.86	-4,744,698,670.92

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	12,950,525,995.23	14,459,081,473.59
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	7,844,429,563.49	8,253,282,095.07
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	4,849,804,300.00	6,068,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	256,292,131.74	137,799,378.52
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	12,064,636,141.15	14,001,510,287.31
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,453,962,352.83	5,319,280,583.59
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,754,967,381.19	2,422,437,440.43
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,378,487,929.03	3,721,135,393.89
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	484,610,135.05	428,486,577.82
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,449,730,225.75	886,167,359.61
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	30,035,835.63	39,998,268.50
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	751,835,999.35	337,354,624.51
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	5,208,000.00	240,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	755,798,282.32	846,410,038.96
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	885,889,854.08	457,571,186.28
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	77,327,761.91	77,488,505.94
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,973,914.85	667,063.37
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.1.8	Бусад	74,353,847.06	76,821,442.57
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	680,225,040.60	934,268,711.50
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	666,365,040.60	928,328,711.50
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	13,860,000.00	5,940,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.2.6	Бусад	0.00	0.00

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-602,897,278.69	-856,780,205.56
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,051,600,000.00	5,048,400,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,051,600,000.00	5,048,400,000.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Бусад	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,336,100,000.00	4,643,400,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,336,100,000.00	4,643,400,000.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Бусад	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-284,500,000.00	405,000,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-1,507,424.61	5,790,980.72
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	53,843,932.37	55,261,278.60
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	55,261,278.60	61,052,259.32

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Зөрүү	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Боловсруулах эрчим хүч	ЦЭХ	сая.кВт.ц	15.8	12.4	8.3	4.1	
	ДЭХ	мян.Гкал	81.9	83.0	85.8	(2.8)	
Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүч	хувиар	хувь	34.3	42.5	54.1	(11.6)	
	биетээр	сая.кВт.ц	5.4	5.3	4.5	0.8	
Түгээх эрчим хүч	ЦЭХ	сая.кВт.ц	10.4	7.2	3.8	3.4	
	ДЭХ	мян.Гкал	79.8	80.9	83.7	(2.8)	
Үүнээс: ДХ ОНӨААТҮГ-т худалдах ДЭХ		мян.Гкал	36.2	39.7	36.2	3.5	
		хувь	45.4	49.1	43.1	6.0	
<b>Нийт орлого</b>		<b>сая төг</b>	<b>14,990.0</b>	<b>13,070.4</b>	<b>13,719.1</b>	<b>(648.7)</b>	
Үүнээс:	<b>Үйл ажиллагааны орлого</b>		<b>сая төг</b>	<b>6,770.1</b>	<b>8,106.1</b>	<b>7,536.3</b>	569.8
	ДЭХ-ний орлого	ЦЭХ	сая төг	2,075.2	1,430.3	776.5	653.8
		ДЭХ	сая төг	4,694.9	6,675.8	6,759.8	(84.0)
	-Үүнээс ДХ ОНӨААТҮГ		сая төг	1,181.5	1,296.1	1,261.8	34.3
	Улсын төсвийн санхүүжилт		сая төг	4,408.9	4,800.0	5,516.4	(716.4)
	Үйл ажиллагааны бус орлого		сая төг	3,811.0	164.4	666.4	(502.0)
<b>Нийт зардал</b>		<b>сая төг</b>	<b>15,197.0</b>	<b>16,050.4</b>	<b>13,829.2</b>	2,221.2	
<b>Үндсэн үйл ажиллагааны зардал</b>		<b>сая төг</b>	<b>14,722.0</b>	<b>15,683.3</b>	<b>13,547.1</b>	2,136.2	
Үүнээс:	түлш	сая төг	5,274.1	4,090.9	3,177.4	913.5	
	элэгдэл	сая төг	1,048.5	1,012.9	1,162.6	(149.7)	
	бусад тогтмол	сая төг	8,399.4	10,579.5	9,207.1	1,372.4	
Үйл ажиллагааны бус зардал		сая төг	475.0	367.1	282.2	84.9	
Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая төг	(207.0)	(2,980.0)	(110.2)	(2,869.8)	
<b>Татварын дараах ашиг /алдагдал/</b>		<b>сая төг</b>	<b>(207.0)</b>	<b>(2,980.0)</b>	<b>(110.2)</b>	<b>(2,869.8)</b>	
Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		төг	2.24	1.98	1.84	0.1	
<b>Нийт авлага</b>		<b>сая төг</b>	<b>265.0</b>	<b>141.4</b>	<b>421.3</b>	<b>(279.9)</b>	

Үүнээс:	ЭХ-ний	сая төг	140.9	141.4	292.5	(151.1)
	Бусад /НА хасагдсан/	сая төг	124.1	-	128.9	(128.9)
<b>Нийт өглөг</b>		<b>сая төг</b>	<b>19,102.9</b>	<b>21,360.3</b>	<b>23,367.7</b>	<b>(2,007.4)</b>
Үүнээс:	Богино хугацаат өр төлбөр	сая төг	14,674.3	14,081.3	14,948.5	(867.2)
	Урт хугацаат өр төлбөр	сая төг	4,428.6	7,279.0	8,419.1	(1,140.1)
Нийт ажиллагсад		тоо	154.0	180.0	180.0	-
<b>Нийт цалингийн сан</b>		<b>сая төг</b>	<b>4,995.6</b>	<b>7,093.1</b>	<b>6,001.4</b>	<b>1,091.7</b>
Жишмэл түлшний хувийн зарцуулалт	ЦЭХ	гр/кВт.ц	1,364.0	1,264.6	1,425.2	(160.6)
	ДЭХ	кг/Гкал	238.7	246.0	230.6	15.4
<b>Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт</b>		<b>сая төг</b>	<b>1,037.3</b>	<b>2,338.9</b>	<b>1,625.6</b>	<b>713.3</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,841.3 сая төгрөгийн 5 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 6,841.3 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан.

*Залруулсан алдаа:*

- Санхүүгийн байдлын тайлангийн Өр төлбөр ба эздийн өмчийн эхний үлдэгдэл 0.02 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Санхүүгийн байдлын тайлангийн Өр төлбөр ба эздийн өмчийн дүн 40.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Орлогын дэлгэрэнгүй тайлангийн өмнөх оны дүнгийн Борлуулалтын орлого 6,770.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Тайлант жилийн цэвэр ашиг 18.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- Даланзадгад сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Дулааны цахилгаан станц хоолны газрын тохижилт" 12.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаагүй байна.

Аудитаар нийт 2,455.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 7 албан шаардлага, 4 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,455.1 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,428.2 сая төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

#### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

#### 3.2 Албан шаардлага

*Илрүүлэлт 1:* Компанийн албан хаагч тус бүрийн цалингаас 0.2 сая төгрөг буюу нийт 7.8 сая төгрөгийг хандивт зарцуулахаар суутгал хийсэн байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-д "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно" гэж заасантай нийцэхгүй байна.

*Илрүүлэлт 2:* Компанийн хөрөнгөөр 2020 онд 165.0 сая төгрөгөөр худалдаж авсан Ковш Lovol FL-955F маркийн 4501УР улсын дугаартай тээврийн хэрэгслийн гэрчилгээ "ТИ ДИ БИ ЛИЗИНГ" ХХК-ны өмчлөгчөөр бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26 дугаар зүйл "Төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах" Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана", Төрийн өмчийн бодлого зохицуулах газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.4-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт 3: Санхүүгийн тайлангаар 1,844.0 сая төгрөгийн өглөгтэй тайлагнасан нь өмнөх оноос 36.0 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт 4: Санхүүгийн тайлангаар 417.1 сая төгрөгийн авлагатай тайлагнасан нь өмнөх оноос 156.3 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт 5: Тэтгэвэрт гарсан харьяаллын өндөр настнууд болон группийн хүмүүст халаалтын улирлын хөнгөлөлтөд зориулан нийт 6.1 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "*хамтын гэрээ*" гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхээр ажил олгогч, ажилтны төлөөлөгчийн хооронд байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн тохиролцоог" гэж заасантай нийцэхгүй байна.

Илрүүлэлт 6: Хамтын гэрээнд заасны дагуу тэтгэвэрт гарсан харьяаллын өндөр настнууд болон группийн хүмүүст "Эрчим хүчний тэргүүний ажилтан" цол тэмдгийн урамшууллыг 2 удаагийн тушаалаар нийт 9.6 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д "*хамтын гэрээ*" гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхээр ажил олгогч, ажилтны төлөөлөгчийн хооронд байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн тохиролцоог", Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн 3.1.1-д "*нэмэгдэл*" гэж энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан ахмад настанд нийгмийн даатгал, нийгмийн халамжийн сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжээс гадна төрөөс сар бүр олгох мөнгөн хөрөнгийг" 5.1-д "Энэ хуулийн 4.1-д заасан ахмад настан мөн хуулийн 3 дугаар зүйлд заасан нэмэгдэл, хөнгөлөлт авах эрхтэй", 5.3-д "Энэ хуулийн 4.1-д заасан ахмад настанд доор дурдсан нэмэгдлийг олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт 7: Тайлант онд Сагсан бөмбөгийн тэмцээнд 2.5 сая төгрөг, волейболын тэмцээний зардалд 2.5 сая төгрөг, дардасны тэмцээнд 0.5 сая төгрөг нийт 5.5 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "*байгууллагын төсвөөр ...спортын уралдаан тэмцээн зохион байгуулах*" гэсэн хориглох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Хамтын гэрээнд заасны дагуу тэтгэвэрт гарсан ажилтнуудад тайлант жилд 60, 70 насны хишиг, "Эрчим хүчний тэргүүний ажилтан" цол тэмдгийн урамшуулал, халаалтын улирлын хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 *"хамтын гэрээ" гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхээр ажил олгогч, ажилтны төлөөлөгчийн хооронд байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн тохиролцоог*" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ахмадын сан байгуулан, тухайн сангаас ахмадтай холбоотой үйл ажиллагаанд зардал гаргаж байх.

Илрүүлэлт 2: Ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл дутуу, ашиглалтад орсон огноо байхгүй, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын тухай гэрээнд тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, аж ахуйн материалын мөнгөн дүн, тоо ширхгийг тусгаагүй байна.

Энэ нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө" Хөдөлмөрийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1-д *"Ажил олгогчийн эд хөрөнгийг захиран зарцуулах, бусдад шилжүүлэх шийдвэр гаргах, эсхүл эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, хадгалах чиг үүрэг бүхий ажилтантай ажил олгогч харилцан тохиролцож, тухайн ажилтны эд хөрөнгийн бүрэн хариуцлагын тухай нэмэлт нөхцөлийг хөдөлмөрийн гэрээнд тусгах, эсхүл энэ талаар дагалдах гэрээ байгуулж болно"*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-д *"Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна"*, Сангийн сайдын 2000 оны 69 дугаар тушаалаар батлагдсан *"Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм"-ийн хоёр Эд хариуцагчийн хүлээх үүрэг-ийн 10-д "Өөрийн хариуцлагад ирж байгаа мөнгөн хөрөнгө, бараа материал, түүхий эд, тоног төхөөрөмж эд хогшил, үнэт цаас, үр тариа зэрэг зүйлийг хүлээн авахдаа түүний тоо, үнэ, чанар, бүрэн бүтэн эсэх болон зохих баримт бичгүүдтэй тохир ч байгаа эсэхийг шалгана"* гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдын эд хөрөнгийн бүртгэлийг чанаржуулж, хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавьж ажиллах.

Илрүүлэлт 3: Компанийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/138 дугаар тушаалаар "Шатахуун зарцуулалтын журам" баталсан байна. Гэвч тооцооллыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Автомашин шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ"-ний дагуу тооцоогүй байна

Өгсөн зөвлөмж: Нормыг үнэн зөв, бодитой тооцоолох.

Илрүүлэлт 4: Агуулахын бүртгэл хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5. *"Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно"*, 13.7. *"Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Агуулахын бүртгэлийг хөтөлж, эд хөрөнгийн бүртгэл хяналтыг сайжруулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн байдлын тайлангийн Өр төлбөр ба эздийн өмчийн эхний үлдэгдэл 0.02 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,	1	0.2			1	0.2	1	0.2				
Санхүүгийн байдлын тайлангийн Өр төлбөр ба эздийн өмчийн дүн 40.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,	1	40.8			1	40.8	1	40.8				
Орлогын дэлгэрэнгүй тайлангийн өмнөх оны дүнгийн Борлуулалтын орлого 6,770.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,	1	6,770.1			1	6,770.1	1	6,770.1				
Тайлант жилийн цэвэр ашиг 18.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн,	1	18.2			1	18.2	1	18.2				
Даланзадгад сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Дулааны цахилгаан станц хоолны газрын тохижилт" 12.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаагүй байна	1	12.0			1	12.0	1	12.0				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>6,841.3</b>			<b>5</b>	<b>6,841.3</b>	<b>5</b>	<b>6,841.3</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд Сагсан бөмбөгийн тэмцээнд 2.5 сая төгрөг, волейболын тэмцээний зардалд 2.5 сая төгрөг, дардасны тэмцээнд 0.5 сая төгрөг нийт 5.5 сая төгрөг зарцуулсан байна	1	5.5			1	5.5		
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>5.5</b>			<b>1</b>	<b>5.5</b>		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Компанийн албан хаагч тус бүрийн цалингаас 0.2 сая төгрөг буюу нийт 7.8 сая төгрөгийг хандивт зарцуулахаар суутгал хийсэн байна	1	7.8			1	7.8						
Компанийн хөрөнгөөр 2020 онд 165.0 сая төгрөгөөр худалдаж авсан Ковш Lovol FL-955F маркийн 4501УР улсын дугаартай тээврийн хэрэгслийн гэрчилгээ "ТИ ДИ БИ ЛИЗИНГ" ХХК-ны өмчлөгчөөр бүртгэлтэй байна.	1	165.0			1	165.0						
Санхүүгийн тайлангаар 1,844.0 сая төгрөгийн өглөгтэй тайлагнасан нь өмнөх оноос 36.0 сая төгрөгөөр өссөн байна	1	1,844.0			1	1,844.0						
Санхүүгийн тайлангаар 417.1 сая төгрөгийн авлагатай тайлагнасан нь өмнөх оноос 156.3 сая төгрөгөөр өссөн байна	1	417.1			1	417.1						
Тэтгэвэрт гарсан харьяаллын өндөр настнууд болон группийн хүмүүст халаалтын улирлын хөнгөлөлтөд зориулан нийт 6.1 сая төгрөгийг олгосон байна	1	6.1			1	6.1						
Хамтын гэрээнд заасны дагуу тэтгэвэрт гарсан харьяаллын өндөр настнууд болон группийн хүмүүст "Эрчим хүчний тэргүүний ажилтан" цол тэмдгийн урамшууллыг 2 удаагийн тушаалаар нийт 9.6 сая төгрөгийн урамшуулал олгосон байна	1	9.6			1	9.6						
Хамтын гэрээнд заасны дагуу тэтгэвэрт гарсан ажилтнуудад тайлант жилд 60, 70 насны хишиг, "Эрчим хүчний тэргүүний ажилтан" цол тэмдгийн урамшуулал, халаалтын улирлын хөнгөлөлт олгосон байна	1	-					1	-				
Ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл дутуу, ашиглалтад орсон огноо байхгүй, эд хөрөнгийн бүрэн хариуцлагын тухай гэрээнд тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, аж ахуйн материалын мөнгөн дүн, тоо ширхгийг тусгаагүй байна.	1	-					1	-				

Компанийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/138 дугаар тушаалаар "Шатахуун зарцуулалтын журам" баталсан байна. Гэвч тооцооллыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Автомашин шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ"-ний дагуу тооцоогүй байна	1	-					1	-				
Агуулахын бүртгэл хөтлөөгүй байна	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>10</b>	<b>2,449.6</b>			<b>6</b>	<b>2,449.6</b>	<b>4</b>	<b>-</b>				